



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2025 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

**Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн
төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдийг чөлөөлөх тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Засгийн газрын 2023 оны 84 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.7.4 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Авто зам, засвар арчлалтын нэгтгэл” төрийн өмчит хувьцаат компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Салбарын бодлого, зохицуулалтын газрын референт С.Нямбаяр, Эдийн засаг, хөгжлийн яамны Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Х.Эрдэнэбулган нарыг компанийн төлөөлөн удирдах зөвлөлд төрийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүнээс 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Боловруулсан

Хяналт

Хувь

132000178

2-r huraldaan.docx